

2024 он 2 сар 5 өдөр

Дугаар 24/01

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

### Бизнес төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 сарын 5-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн 2023 оны 10 сарын 26-ны өдрийн 23/31 тоот тогтоолоор баталсан компанийн 2024-2026 оны стратеги төлөвлөгөөний хүрээнд боловсруулсан компанийн 2024-2026 оны бизнес төлөвлөгөөг тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу удирдан зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Б.Золбоо)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2024 он 2 сар 5 өдөр

Дугаар 24/02

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

### Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл 46.1, 46.2, 46.5, 46.6 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2 сарын 5-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2023 оны санхүүгийн жилд хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан хуульд заасны дагуу ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Б.Золбоо)-д даалгасугай.

